

БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ ЦТ ХХК-ИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.04.

Баянхонгор

Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар “Ёс зүйн дэд хороо” 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Хорооны даргаар дотоод хяналтын ажилтан Б.Энхтуяа, нарийн бичгээр инженер Б.Батцэрэн нар сонгогдсон.



Ёс зүйн дэд хороо нь 5 удаа хуралдаж 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, 11 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Гүйцэтгэх захирлаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулж, өнөөдрийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байв.

1. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө, “Ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын “Ил тод мэдээллийн самбар” болон <https://bhrpower.mn/> цахим хуудасны “Ил тод байдал” хэсэгт, байршуулан, олон нийтэд ил тод мэдээллэж, сурталчилж байна.

2. Мөн албан хаагчдын ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүй” “Хүний эрх, хүний эрхийн зөрчлийн тухай” сэдвүүдээр нийт албан хаагчдад 2 удаагийн сургалт зохион байгуулж, харилцан ярилцсан. Сургалтад нийт 94 албан хаагч хамрагдсан.



3. Компанийн нийт ажилчдыг ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах шаардлагын хүрээнд “Ёс зүй сахилга хариуцлагын гэрээ” байгуулж хөдөлмөрийн гэрээний хавсралт болгон ажиллаж байна.



4. Албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирсэн 5 гомдлыг хороогоор хэлэлцэж шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд иргэдээс ажилтан албан хаагчтай холбоотой гомдол мэдээлэл ирүүлээгүй байна.



4 САР СУРГАЛТ НӨЛӨӨЛЛИЙН САР

2025 оны 04-р сарын 09-ны өглөө 08.00 цагт Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Ш.Гэрэлсүхийг урьж "Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал" –ын талаар сургалт, ярилцлага хийлээ .



Аймгийн ЗДТГ-ын “Ёс зүйн дэд хороо”-ноос байгууллагуудын хорооны дарга нарт “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр сургалт хийж уг сургалтад компанийн Ёс зүйн дэд хорооны дарга Б.Энхтуяа хамрагдсан.



2025 оны 04-р сарын 25-ны өдөр "Ёс зүйгээр манлайлагч байгууллага" болзолт уралдааны хүрээнд Баянхонгор аймгийн ЕБС-ын 9,10-р ангийн 68 сурагчдад "Зөв ёс зүйг түгээе" сэдвээр сургалт хийж ёс зүй гэр бүлээс, ёс зүй нийгмээс, ёс зүй найзуудаас, ёс зүй хувь хүнээс шалтгаалдаг талаар ярилцаж хүүхдүүдийн дунд хамгийн их ёс зүй зөрчигдөж байгаа зүйл нь ЭЛЕКТРОН ТАМХИ болох талаар хөндөж түүний эдийн засаг, эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж буй хор хөнөөлийн тухай ярилцав.



2025 оны 05-р сарын 26-ны өдөр "Алгоритм" сургуулийн Ирээдүйн мэргэжлийн замналын чиг баримжаа олгох "Ирээдүйн эзэд" өдөрлөгт Техникийн бодлого төлөвлөлт туршилт тохируулгын албаны ахлах инженер Д.Гантулга оролцож цахилгааны инженер мэргэжил сонирхож буй сурагчдад өөрийн эрхэлдэг ажлын сайхан бөгөөд эрсдэлтэй асуудлууд, мэргэжлийн ёс зүйн тухай мэдлэг олгох сургалт хийж ирээдүйн инженер сурагчидтай халуун дотно яриа өрнүүллээ.



5



САР ТАЛАРХАЛЫН САР

Ажилчид “Сөрөг бодлоо гээснээр эерэг бодол бодох боломжийг өөртөө өгөх” хамт олныхоо дунд таатай уур амьсгал, ёс зүйтэй соёлыг бүрдүүлэхийн тулд 5 сарыг ТАЛАРХАЛЫН САР болгосон. Энэ хүрээнд ажилчдынхаа дунд

1. "ТАЛАРХАЛЫН 7 ХОНОГ" аян зарлаж аймгийн төвийн 44 ажилтан хамрагдсан. Бие биедээ талархсан сэтгэлээ илэрхийлж, эерэг харилцаа хандлага түгээсэн хамт олондоо талархая.



2. “ГЭР БҮЛДЭЭ ТАЛАРХАЯ 7 хоногийн аян.

- a) Болзолт уралдааны хүрээнд Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан – “АЗ ЖАРГАЛТАЙ АЖЛЫН БАЙР- ХАЙРААР ТЭТГЭГДСЭН ГЭР БҮЛ” 7 хоногийн аян зохион байгуулж ажилтнуудын ар гэрээс ирсэн бичлэгүүдийг нэгтгэн контент болгож хайртай гэр бүлийнх нь талархалын мэндчилгээг ажилчиддаа танилцуулж урам хайрлав. /бичлэгээр/
- b) Мөн Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан компанийн ажилчдын гэр бүлийн гишүүдийн дунд “Волейбол-ын тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд ажилчдын ар гэрээс ирсэн хүмүүсийг эрэгтэй 3, эрэгтэй 3 багт хувааж 50 орчим тамирчид оролцож өрсөлдсөн.

Эрэгтэйчүүдээс:

- 1- р байранд ЗАА баг
- 2- 2-р байранд ХҮТ-ийн баг

Эмэгтэйчүүдээс:

- 1- р байр Шугамын баг
- 2- р байр ЗАА баг тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

Ингэснээр гэр бүл чөлөөт цагаа зөв өнгөрөөх, гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлэх, тэднийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, байгууллагаа танилцуулах зэрэг ач холбогдолтой спортын үйл ажиллагаа болсон.





ЭНХРИЙ ҮРСДЭЭ БАЯРЛАЛАА

2025 оны 05-р сарын 31-ны өдөр Алдарт эхийн 2-р одон авсан ХҮТ-ийн ахлан инженер В.Баттөр, ЦШС-ний монтёр Х.Баттулга, жолооч Х.Бат-Оргил нарынхаа гэр бүлд баяр хүргэж цэцгийн баглаа барьлаа.





Мөн 5-р сарын 31-ны өдөр компанийн ажилчдын 150 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, 3 насны ангилалд уралдаан тэмцээн зохион байгуулж, бүх хүүхдэд гарын бэлэг гардуулан 3,2 сая төгрөг зарцуулж, хүндэтгэл үзүүллээ.





ДЭВЖЭЭ ТЭМЦЭЭН

Болзолт уралдааны хүрээнд гаргасан төлөвлөгөөний дагуу Ажилтан албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах, хууль сурталчлах,



ажилчдын оролцоотой тэдний хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хамт олноороо чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК-ийн ажилчдын дунд “Дэвжээ тэмцээн”-ийг 2025 оны 05-р сарын 15-ны өдөр зохион байгууллаа. /Удирдамжийг хавсаргав/

- 1- р байранд: Захиргаа аж ахуйн баг
- 2- р байранд: Хэрэглэгчид үйлчлэх төвийн баг
- 3- р байранд : ЦШСШҮ-ний албаны баг тус тус шалгарч шагнагдсан.





Болзолт уралдааны хүрээнд мэдээллийн ил тод байдал ба ажилчдын мэдэх эрхийг хангах зорилгоор “Ёс зүйн дэд хороо”-ны мэдээллийн самбартай болж холбогдох мэдээллүүдийг ажилчдад танилцуулж ажиллав.

Удирдамжинд заасны дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээгээр 1 контент, ёс зүйн тухай хууль болон төрийн албан хаагчийн хэм хэмжээгээр 3 төрлийн постер бэлтгэн байгууллагын албан ёсны цахим хуудас <https://bhrpower.mn/>-аар

олон нийтэд түгээж , хандалт авч байна.

Баянхонгор аймгаас зохион байгуулсан Дэвжээ тэмцээнд Төрийн өмчит компаниудаад ганцаараа оролцож зохион байгуулагчдын талархалыг хүлээсэн.

2025 оны төлөвлөгөөний дагуу “Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд Компанийн залуучуудын холбоотой хамтарч нийт ажилчдынхаа дунд 2025 оны 09-р сарын 13-ны өдөр “Үүргэвчтэй аялал” байгуулсан.

Ажилчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, тэдний хоорондын нөхөрлөл, хамтын ажиллагаа, багийн эв нэгдлийг гүнзгийрүүлэх, эрүүл агаарт гарах, биеийн алжаал болон оюуны ядаргааг тайлахад аялалын зорилго оршиж байсан.

№	Үйл ажиллагаа	Цаг	Зохион байгуулах ажилтан
1	Цуглах /багуудын хамгийн сүүлийн гишүүний ирсэн цагаар цагийг бүртгэнэ/	09.40- 10.00	Ёс зүйн дэд хорооны дарга Б.Энхтуяа
2	“Оргил өөд хамтдаа” тэмцээн /Багийн гишүүн бүр үүргэвчээ үүрээд “Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК-ийн туг хатгасан” оргил өөд гарч өөр өөрсдийн жигдэрсэн өнгө бүхий тугийг мандуулна. Багийн хамгийн эхний болон хамгийн сүүлийн гишүүний хурдаар багийг байр эзлүүлнэ/	10.00-11.30	Ёс зүйн хороо
3	Цайлах /үдийн цай, хөнгөн зууш ажилчид өөрсдөө бэлтгэн үүргэвчиндээ хийж ирэх /	11.30-12.00	Багийн ахлагч нар
4	Булаг дээр ирэх	12.00 -12.30	Багийн ахлагч нар
5	Баг тус бүрийн мэндчилгээ /Багийн гишүүд бүгд оролцох /	12.30-13.30	Зохион байгуулагчид
6	Өдрийн хоол /Багууд аялалын хүнсээ бэлтгэнэ/	13.30-14.30	Багийн ахлагч нар
7	Багуудын дунд хөгжөөнт буухиа тэмцээн	14.30-15.00	Залуучуудын холбоо
8	Корн холл тэмцээн	15.00-15.30	ХАБ инженер
9	Шилдэг баг шалгаруулах, шагнал олгох	15.30-16.00	Зохион байгуулагчид , удирдлагын баг
10	Буцаж алхан компани дээр ирэх, амрах	16.00-17.00	Багийн ахлагч нар

Дээрх хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан явган аялалд К.Амарбаатар ахлагчтай баг 1-р байр, Б.Бадамцэцэг ахлагчтай баг 2-р байр, Ж.Уламбаяр ахлагчтай баг 3-р байр тусгай байрыг Д.Батхүлэг ахлагчтай багууд тус тус эзлэсэн.









“Хүндэлье, энэрье” аян зохион байгуулах тухай албан бичгийг 2025 оны 11-р сарын 12-ны өдөр хүлээн авч компанийн “Ёс зүйн дэд хороо” хуралдаж байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжлийн тухай, аяныхугацаанд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн шийдвэрлэж Гүйцэтгэх захирлаар батлуулж хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа.

1. Ажилчид “Сөрөг бодлоо гэсэнээр эерэг бодол бодох боломжийг өөртөө өгөх” хамт олныхоо дунд таатай уур амьсгал, ёс зүйтэй соёлыг бүрдүүлэхийн тулд аяны хүрээнд “ТАЛАРХАЛЫН 7 ХОНОГ” аяныг 2 дахь



удаагаа зарлаж аймгийн төвийн 31 ажилтан хамрагдсан. Бие биедээ талархсан сэтгэлээ илэрхийлж, эерэг харилцаа хандлага түгээсэн хамт олондоо талархья.

2. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байсан “Нийт албан хаагчидтай ёс зүй, сахилга хариуцлагын гэрээ” байгуулах хүрээнд 13 ажилтан дутуу хамрагдсан байсан. Аяны хугацаанд 13 ажилтантай уг гэрээг байгуулж 1 хувийг хүний нөөцийн менежер К.Амарбаатарт хүлээлгэн өгч төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангав.

**БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ” ЦТ ХХК-ИЙН
АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

“БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ” ЦТ ХХК-ИЙН ЁС ЗҮЙ хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль” Засгийн газрын 33 дугаар тогтоолоор баталсан “ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” байгууллагын дотоод журам болон бусад хууль тогтоожинд заасан нийтлэг үүрэг, ажилтнуудын баримтлах “ Ёс зүйн дүрэм”-ийг баримтлан гэрээг байгууллагын нийт албан хаагч ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулж, баталгаажуулан танилцуулан 2 хувь үйлдэж ажилтан бүрд танилцуулан хувийн хэрэгт хавсарган хүний нөөцийн менежерт хүлээлгэн өгөв.

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

ЁС ХОРООНЫ ГИШҮҮН

/ Б.АЗЖАРГАЛ /

ХҮЛЭЭН АВСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР

/ К.АМАРБААТАР /

3. 11 сарын бичилтээр гэр хороолол, орон сууцны байруудын дэд станцуудаар яваа ажилчдаа Ёс зүйн дэд хорооны хамт олноос халуун чацаргана , амттан өгч хүндлэл үзүүллээ.



ТАЙЛАН БИЧСЭН:

ЁС ЗҮЙ ДЭД ХОРООНЫ ДАРГА Б.ЭНХТУЯА